



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 25 өдөр

Дугаар А/408

Хэрлэн сум

Тусгай зөвшөөрөл сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.17, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 53 дугаар тогтоолын 5.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комиссын 2022 оны 8 дугаар сарын 16-ны хуралдааны шийдвэрийг үндэслэн эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан байгууллагын нэрсийг хавсралтаар баталсугай.

2. Дээрх байгууллагуудын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга (Л.Мэндбаяр)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комиссын дарга бөгөөд Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2022
дугаар сарын 25-ны
захирамжийн хавсралт

Тусгай зөвшөөрөл сунгасан байгууллагуудын нэрс

№	Тусгай зөвшөөрөл эзэмших байгууллагын нэр	Тусгай зөвшөөрөл сунгасан хугацаа	Хүчинтэй хугацаа
1	Бор-Өндөр сумын "ЭЭС Бодь" ХХК-ийн эмийн сан	2 жил	2022.08.05- 2024.08.05
2	Батноров сумын "Амгалан буян" ХХК-ийн эмийн сан	9 сар	2022.08.16- 2023.05.05
3	Батширээт сумын "Бөөн шинэс" ХХК-ийн эмийн сан	10 сар	2022.08.16- 2023.06.30